



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 01

Арвайхээр

**“Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлийн
эргэн төлөлтийг сайжруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. “а”, Монгол Улсын Засгийн газрын 153 тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.2.1, 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст

1.1. “Сум хөгжүүлэх сан”-гийн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нь тухайн суманд хуваарилагдсан хөрөнгийн 10 хувиас хэтэрсэн тохиолдолд эх үүсвэрийг эргэн төвлөрүүлэх хүртэл сангийн зарлагыг бүрэн хаах

1.2. Сумдын ажлыг дүгнэж, урамшуулахдаа “Сум хөгжүүлэх сан”-гийн эргэн төлөлтийн хувийг нэг үзүүлэлт болгон авч үзэх

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт

2.1. Сумдын “Сум хөгжүүлэх сан” хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах

2.2. Сумдаас ирүүлсэн сангийн мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн дүгнэхдээ тоо, мэдээ зөрүүлэхгүй, журмын дагуу үнэн зөв тайлагнаж хэвших

2.3. Сангийн эргэн төлөлтийн мэдээг сум тус бүрээр гаргаж улирлын сүүлийн сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлж байх

3. Аймгийн Цагдаагийн газарт

3.1. “Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаад зээлээ зориулалтын бусаар зарцуулсан, гэрээний хугацаа хэтрүүлсэн, өөр аймаг, сум руу шилжээд хаяг тодорхойгүй, холбогдохгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн өрийг барагдуулах ажил зохион байгуулахад сумдын Засаг даргын Тамгын газартай хамтран ажиллаж үр дүнг тайлагнах

4. Сумын Засаг дарга нарт

4.1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын дагуу хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулах

4.2. Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжүүдтэй байгуулах гэрээнд зээлдэгчийн хариуцлагын талаар нэмэлт заалтыг оруулан үйл ажиллагаа

011200001

2.

эхлүүлэх хугацааг заах, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй тохиолдолд буцаан татах, гэрээг цуцлах талаар тусгах

4.3. Бусад сангуудаас зээлтэй, зээлийн муу түүхтэй иргэн, аж ахуйн нэгжид сангаас зээл олгохгүй байх

4.4. Сан хариуцсан мэргэжилтнүүд сар бүр зээлдэгчдийн эргэн төлөлтөд хяналт тавьж, зээлийн үлдэгдлийг тулган, зээлийг гэрээний хугацаанд төлүүлж, өр авлага үүсгэхгүй ажиллах

4.5. "Сум хөгжүүлэх сан"-гийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан тухай Монгол банкны мэдээллийн санд бүртгэгдэх талаар албан мэдэгдлийг зээлдэгч нэг бүрт хүргэж, хэрэв гэрээнд заасан хугацааг зөрчихөд чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлтэй тухай лавлагаа гарахыг урьдчилан анхааруулах


4.6. Хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан болон амжилттай хэрэгжүүлж байгаа төслүүд, зээлийн гэрээг зөрчин хугацаа хэтрүүлсэн, зориулалтын бусаар зарцуулсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг олон нийтэд ил тод байршуулан хяналт тавиулж, зээлдэгчид болон төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх

4.7. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлтэй зээлдэгчдийг шүүхэд шилжүүлэх, сумын хэсгийн төлөөлөгчтэй хамтран хяналт тавьж үр дүнг 2019 оны 3 дугаар улирлын мэдээнд тусган аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт албан бичгээр ирүүлэх

5. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах

5.1. Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), аймгийн Цагдаагийн газар (О.Ганбат)-т, сумын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД